

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлд:

“XI.8.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав:

1.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ чиглэлийн ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;

2.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг шинэчилсэнтэй холбогдуулан уг цахим системийг хөрөнгө оруулалтын бүх үйл ажиллагаанд бүрэн ашиглаж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж ажиллах болон төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР